

ГАРЧИГ

1.1. Төслийн товч тодорхойлолт	2
ОРШИЛ.....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	8
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	8
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	8
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	9
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .	9
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	15
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
9. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС	16
10. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ.....	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	2
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим	4
Хүснэгт 3. Хөрсний овоолгын төлөвлөлт	5
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил	15
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 10. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	24
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	26
Хүснэгт 12. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	27

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь Хуурай чулуутын алтны шороон ордын доод хэсэг нь Улаанбаатар хотоос 150 орчим км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 55 км, Шарын голын нүүрсний уурхайгаас 10 км зайд байрлана. “Эгэмайнинг” ХХК-ийн эзэмшлийн MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнь М-48-106 дээр байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

Д/д	өргөрөг			Уртраг			Д/д	өргөрөг			уртраг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	106	35	13.22	49	13	19.42	10	106	33	55.26	49	13	25
2	106	35	13.22	49	13	19.42	11	106	33	55.26	49	13	13.91
3	106	35	21.32	49	13	21.59	12	106	34	3.32	49	13	11.34
4	106	35	21.21	49	13	21.99	13	106	34	15.89	49	13	7.32
5	106	35	21.1	49	13	22.4	14	106	34	17.34	49	13	6.38
6	106	35	32.53	49	13	27.16	15	106	34	36.51	49	12	53.92
7	106	35	32.53	49	13	31.71	16	106	34	48.65	49	12	53.92
8	106	35	35.1	49	13	28.88	17	106	34	48.65	49	13	4.5
9	106	35	35.1	49	13	25	18	106	35	13.22	49	13	4.5



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

ОРШИЛ

Хайгуулын ажлын үр дүнгээр ордын хэмжээнд бодитой В зэрэглэлийн 7-н блокод 60.98 мян.м3 элсэнд 316.68 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 19.31 кг, химийн цэврээр 16.92 кг алтны нөөц, боломжтой С зэрэглэлийн 4-н блокод 26.63 мян.м3 элсэнд 305.2 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 7.67 кг, химийн цэврээр 6.72 кг алтны нөөц, нийт бодитой болон боломжтой зэрэглэлээр 87.61 мян.м3 элсэнд 313.19 мг/м3 дундаж агуулгатай шлихээр 26.98 кг, химийн цэврээр 23.64 кг алтны нөөцийг тооцжээ.

2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим

“Хуурай чулуут”-ын алтны шороон ордын доод хэсэг нь хөндий дагаж, зүүн хойшоо сунаж тогтсон, зөрөлт, зөрөлт-шилжилт хагарлаар зааглагдаж шаталсан байдалтай доош суусан, тууз хэлбэрийн блок үүсгэнэ. Алтны шороон орд суналын дагуу 520 м (доод) – 545 м (дээд) хүрэх ба өргөн нь 45-100 м байна. Уг орд нь дээд, доод 2 давхаргаас бүрдэх бөгөөд дээд давхраас нь 6 блок, доод давхраас нь 5 блокторой. “Хуурай чулуут”-ын орд нь геологи структурын тогтцын хувьд нийлмэл, хүдрийн биеийн ашигт давхарга тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, алтны доод (доош суусан) ба дээд (дээш өргөгдсөн) давхарга, зөрөлт, ашигт давхарга харьцангуй зузаан зэргийг харгалзан үзэж III-р бүлгийн алтны шороон ордын шаардлагад нийцсэн гэж үзээд ордыг III-р бүлгийн ордод хамааруулсан байна. Хучаас хөрсний хамгийн зузаан нь хэсэг нь С-1 блокт 10.4 м, ашигт давхаргын хамгийн зузаан нь С-2/1 блокт 2.13 метрээр тус тус тооцсон байна.

Ордын алт агуулсан элс, хөрсний зузаан, газарзүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэргээс хамааруулан 2024 оны ашиглалтын жилд авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системийг хослуулж ашиглана.

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Шимт хөрс хуулалт	1.1. Ухаж түрэх
	2. Хөрс хуулалт	2.1. Ухаж түрэх 2.2. Ухаж ачих 2.3. Тээвэрлэх 2.4. Овоолох
	3. Элс олборлолт	3.1. Ухаж ачих 3.2. Тээвэрлэх 3.3. Овоолох (агуулахад хураах)

Ажиллах горим.

Уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд баяр ёслолын болон амралтын үед ажилчдын амрах хугацааг МУ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу болон уурхайн даргын тушаалаар зохицуулна. Мөн бүс нутгийн цаг агаарын онцлог, уул тээврийн тоног төхөөрөмжүүдийн ажлын бэлэн байдал, тэдгээрийн техникийн нөхцөл боломжуудаас хамааран 2024 онд ажиллах хоногийн тоог тооцож хүснэгтээр үзүүлээ. Уурхай нь улирлын чанартай ажиллах тул 2024 онд 7-р сарын 1-ээс эхлэн бэлтгэл ажлыг хангаж, 7-10-р сарыг дуустал хугацаанд бэлтгэл ажил, амралт, баяр ёслол, засвар үйлчилгээний сул зогсолтоо тооцоод нийт 108 хоногийн хугацаанд ажиллахаар тооцоолов.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Календарь цаг
2024 онд			
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
2	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	2
3	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	108
4	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	216
5	Жилийн календарь цаг	цаг/жил	2160

Ил уурхайн хүчин чадал, техник-технологи

Ил уурхайн хүчин чадал. 2024 оны 7-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, уурхайд компанид байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд ордын үлдсэн нөөц болох 47.94 мян.м3 алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана. Мөн тухайн онд хаалт нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2024 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.

Уурхайн уулын ажлын төлөвлөлтөөр 2024 онд 399.67 мян.м3 уулын цулыг уурхайгаас олборлоно. Одоогоор компанийн эзэмшилд VOLVO 460 маркийн 1 ш экскаватор, Hyundai R2900 маркийн 1 ш экскаватор, Weichai маркийн 70 тн даацтай 4 ш автосамосвал, Shantui SD-13 маркийн бульдозер 1 ш, ZI-50 маркийн утгуурт ачигч 1 ш зэрэг үндсэн техник тоног төхөөрөмжүүд бэлэн байна. Эдгээр тоног төхөөрөмж нь төлөвлөж буй ил уурхайн хүчин чадлыг бүрэн хангана. Хөрсний овоолго байгуулах, элсний овоолго түрэх, эфель гааль, шлам хураах бусад туслах ажилд, Shantui SD-13 бульдозер болон XCMG ZI-50 маркийн утгуурт ачигч ажиллана.

II.3. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2024 оны 07-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Ашиглалтын хоёр дахь жил буюу 2024 онд ордын Дээд, доод давхаргын С-1, В-1, В-2, В-3, В-4, С-2, С-1/1 гэсэн блокууд дээр ажиллахаар төлөвлөв. Дээрх блокуудаас нийтдээ 2024 онд 351.73 мян.м3 /сийрэгжилт тооцсоноор 404.5 мян.м3/ хөрсийг дотоод овоолгод хураана. Мөн баяжуулах төхөөрөмж энэ оны 7 сараас ажиллаж эхлэх бөгөөд тухайн жилд 47.94 мян.м3 элс угааж баяжуулна.

III.1. Олборлолтын процесс

Ил уурхайн үндсэн үйл ажиллагаа нь уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээлийг хангах ёстой.

Уурхайд дараах процессууд явагдана:

1. Өнгөн хөрсийг түрэх
2. Хөрс болон алт агуулсан элсийг түрэх, ухаж ачих, тээвэрлэх
3. Овоолго үүсгэх

Хөрс хуулалтын ажилд VOLVO 460 маркийн экскаватор, элс олборлолтын ажлыг Hyundai R2900 маркийн экскаватор болон 70 тн даацтай Weichai автосмосвалын хослолоор гүйцэтгэнэ.

Автосамосвалын тооцоо. Уурхайд хөрс болон элс тээвэрлэлтийн ажил нь авто тээврээр хийгдэнэ. Уурхайгаас гарах хөрсийг тээврийн зай хамгийн бага, техникийн нөхөн сэргээлт хийхэд хялбар байх зэрэг нөхцөлүүдийн үндэслэн дотоод овоолгод хураана. 2024 онд хөрс тээврийн зай 0.6 км, элс тээврийн зай 0.8 км байна. Тээврийн ажилд автосамосвалын

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ачаатай /элс/ явах дундаж хурд 20 км/цаг, хоосон явах дундаж хурд 30 км/цаг ба хөрс тээвэрлэх үед ачаатай явах хурд 18 км/цаг, хоосон үед 25 км/цаг байна.

уурхайн хөрсний тээвэрлэлтэд БНХАУ-ын 70 тн даацтай автосамосвал 2 ш, элс тээвэрлэлтэнд 1 ш автосамосвал байхад хангалттай харагдаж байна.

Бульдозерын тооцоо. Тус уурхайн хэмжээнд шимт хөрсийг хуулах, дотоод овоолго байгуулах, ажлын талбайг засах, нөхөн сэргээлтийн ажил хийх, ашигт малтмалын давхаргын ул, таазны цэвэрлэгээ хийх зэрэгт бульдозер ашиглах бөгөөд эдгээр ажилд SD-13 маркийн бульдозер ажиллуулахаар тооцлоо.

Хөрсний овоолго. Хөрсний гадаад овоолгыг уурхай хажууд буцааж дүүргэхэд хялбар байх техникийн шийдлийг харгалзан байршуулна. 2024 оны ашиглалтын жилд уурхайн дээд доод давхаргаас гарсан 351.7 мян.м3 /сийрэгжээгүй/ хөрсийг дотоод овоолгод хураахаар төлөвлөв.

Хүснэгт 3. Хөрсний овоолгын төлөвлөлт

№	Ашиглалтын жил	Хэмжих нэгж	Хуулах хөрс	Сийрэгжилт тооцсон
1	2024 онд	мян.м3	351.73	404.5

Элсний түр овоолго. Энэ жилд дунджаар 47.9 мян.м3 элс олборлоно. Уурхайгаас олборлох элсийг уурхайн хажууд байрлах баяжуулах үйлдвэрийн дэргэд түр агуулахад хураан ZI-50 маркийн утгуурт ачигчаар баяжуулах төхөөрөмжийг тэжээнэ.

Замын ашиглалт, үйлчилгээний процесс

Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, халтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр элс, давс цацах, цас мөс арилгах, замыг цас бороо болон шар усны үерээс хамгаалах, зам усалгаа тоос дарах зэрэг ажлууд орно.

Уурхайн бусад тээвэр. Ил уурхайн замыг байнга хянах ба засаж тэгшлэх, цэвэрлэх, тоос дарах ажиллагааг гүйцэтгэнэ. Эдгээр ажилд компанид байгаа усалгааны машин, XCMG ZI-50 утгуурт ачигч зэрэг тоног төхөөрөмжийг ашиглана. Ил уурхайн тоног төхөөрөмжүүд нь ээлжид 0.5-1 тн түлш хэрэглэнэ. Тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангах 3 тн даацтай түлш цэнэглэгч автомашин ажиллана. Уурхайд ажиллах инженер техникийн ажилчдын ашиглах жийп машин 2 ширхэг байна.

БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ

V.1. Ерөнхий мэдээлэл

“Эгэмайнинг” ХХК-ийн Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын алт агуулсан элснээс 2021 онд 260 кг сорьцонд “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын лабораторид технологийн туршилт шинжилгээ гүйцэтгэсэн байна.

Туршилт шинжилгээний ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд: Эрдсийн найрлагын нарийвчилсан судалгаа, Гравитацын баяжигдах чанарын туршилт шинжилгээ, дүгнэлт; тухайн орд газрын хэсгээс авсан технологийн сорьц дээжийг гравитацийн аргаар баяжуулах технологийн схемийг боловсруулан алт агуулсан баяжмал ялгах туршилт шинжилгээг явуулсан байна

V.2. Баяжуулах хэсгийн технологи схем, бүтээгдэхүүн гаргалт


Шороон ордын алт баяжуулах үндсэн технологи нь уг ордын эрдсийн бүрэлдэхүүний онцлог, угаагдах шинж чанарт тохирсон технологийн горимыг сонгож авдаг. Тухайн ордын онцлогт тохирсон технологи нь алт агуулагч чулуулгийн найрлага, бүтэц, угаагдах шинж чанар, материалын ширхэглэлийн хэмжээ, тоосонцор алтны эзлэх хувь, агуулга, хэлбэр хэмжээ, шигшүүрийн нүхний диаметр, металл хуримтлал, технологийн ус, хатуу шингэний харьцаа, насосын даралт, усны эрчим зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаардаг.

Элс угаан задлалт: “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын алт агуулагч элс нь угаагдах шинж чанарын хувьд хялбар угаагдах ангилалд багтаж байгаа учир угаан задлах ажиллагааг скруббер ашиглан гүйцэтгэнэ. Ингэснээр алт агуулагч элсийг сайтар угаан задалж баяжуулалтад оруулахад бэлэн болгоно. Скруббер нь +20мм-ийн ангиллыг галийн овоолгод хураана. Харин -20мм –ийн ангиллын элсийг шлюзэд тэжээнэ.

Элс угаан баяжуулалт: -20мм-ийн ширхэглэлтэй элсийг нам дүүргэлтийн гидро шлюзээр баяжуулна. Энд том ширхэгтэй алт суух бөгөөд нам дүүргэлтийн шлюзийн баяжмал нь харьцангуй их хэмжээний элстэй байх учир алт агуулсан баяжмалыг зориулалтын саванд хийж гүйцээн баяжуулах цехэд авчирч баяжуулна. Хаягдал нь хаягдлын санд урсан орж тунана. Гүйцээн баяжуулахад ирсэн баяжмалыг шигшин, -2.0 мм ангиллын бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээгээр баяжуулах ба +2.0 мм ангиллын бүтээгдэхүүн болон ширээний баяжмалыг гар тэвшээр баяжуулан соронзон ялгагчаар ялгаж хатаагаад гар аргаар үлээнэ.

Хаягдлын сан: Скрубберээс гарсан +20мм-ийн ангиллыг галийн овоолгод хураах бөгөөд нам дүүргэлтийн шлюзийн хаягдлыг хаягдлын санд хураана. Хаягдлын санд тунаж цэвэршсэн ус эргэлтийн усан санд өөрийн урсгалаар урсан орно. Эргэлтийн усан санд хуримтлагдсан усыг технологийн процесст эргүүлэн ашиглана.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 2. Баяжуулах технологийн схем

Хаягдлын далан. Ордын 2024 оны ашиглалтын жилд баяжуулах цехээс 47.87 мян.м3 эфел, гаалийн хаягдал гарах ба үүнийг уурхайн ашиглагдсан орон зайд нөхөн дүүргэлт хийж нөхөн сэргээх боломжтой байна. Хаягдлын агуулга 21.5 мг/м3. Хуурайн чулуутын алтны шороон ордын элсийг усаар задлахад гарах шламын тунах хурд хурдан, шаврын агууламж нь харьцангуй бага тул одоо ашиглаж байгаа нэг нууртай хаягдлын технологийг үргэлжлүүлэн ашиглана. Хаягдлын сангийн багтаамж нь ойролцоогоор 8600 м3 байна. Цэвэр усны сангийн хэмжээ 5900 м3 байна. Баяжуулах үйлдвэрт зарцуулах нэмэлт цэвэр усны хэрэглээг Шарын голоос татан хангахаар төлөвлөв.

Ундны усан хангамж. Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 32 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжид буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Хоногт зарцуулагдах хэрэглээний усны 1 хүнд оногдох хэмжээ дунджаар 25 л гэж үзвэл, нийт хэмжээ 800 л буюу 0.8 м3/хон (0.01 л/сек) болно. Унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд залгаа талбайд байх худгаас хангана. Гүний худгийн усны ундарга нь 3.7 л/сек бөгөөд ахуйн усны хэрэгцээг бүрэн хангах боломжтой байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль, цаг уур: Судалгааны талбай Шарын голын цутгал, түүний ай савд багтах Хуурай чулуутын хөндийн усан сүлжээнд багтана. Цаг уурын хувьд талбайн нь эх газрын эрс тэрс уур амьсгалтай, жилийн агаарын температурын өөрчлөлт их, халуун хүйтнийх хязгаар жилийн дөрвөн улиралд харилцан адилгүй байдаг. Дулааны улирал 7 сард дунджаар +25-25°C , хамгийн халуун нь +35°C хүрдэг байна. Жилд унах хур тунадасны хэмжээ 244 мм байх ба зун намрын улиралд нийт тунадасны 70 хүртэл хувь нь борооны ус байдлаар унадаг.

Ургамлын бүрхэвч: Хөрс ургамлын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, харьцангуй хуурайшилт багатай байгалийн онцлог бүхий мужид оршдог зэргээс хамааран ялзмаг ихтэй хар хүрэн хөрс зонхилон тархсан бөгөөд манай орны газар тариалангийн гол бүс нутаг юм. Ой модтой хэсэгт модлог ургамлаас гадна шим сайтай сахлаг өвс ургадаг тул хадлангийн гол нөөц болдог. Голын хөндийнүүд ба тэгш талархаг хэсэг нь газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой.

Цаг уурын онцлог хөрсний төрлөөс тал хээрийн ургамал сийрэг байдлаар тархсан байдаг. Голлон дааган сүүл, биелэг өвс, хиаг, шивээнт хялгана, агь зэрэг өвслөг ургамал уулын хажуу, хөндий хоолойг бүрхсэн байдаг бол голын эрэг хөвөөг даган дэрс, хөх цахилдаг зэргээс гадна бут бутлаг ургамлын төрөл элбэг тохиолддог.

Ан амьтан: Амьтны аймгийн хувьд тал хээрийн ан амьтнаар баялаг. Араатнаас чоно, үнэг, хярс, мэрэгчдээс тарвага зурам, алаг даага, оготно, хулгана, жигүүртнээс бүргэд , харцага, ятуу, ногтруу зэргээс гадна усны шувуудаас алаг нугас, бор галуу, өрөв тас зэрэг амьтад нутагладаг.

Зам харилцаа, дэд бүтэц: Ордын талбайд хамгийн ойр орших томоохон суурин газар болох Хонгор тосгон нь 6 км, Дархан хоттой 65 км төмөр замаар, 50 км урт шороон замаар холбогдоно. Тус тосгон нь дэд бүтцийн хөгжил маш сайн хөгжсөн цахилгаан эрчим хүчний шугам, авто замын сүлжээ, орчин үеийн хөдөлгөөнт харилцаа холбооны сүлжээнд холбогдсон эдийн засгийн маш тааламжтай бүсэд оршино. Тосгоны төв 12000 гаруй хүн амтай, орон сууцны тохилог байруудтай тэдгээр нь тосгоны нэгдсэн халаалтын системд холбогдсон 11 жилийн дунд сургууль, цэцэрлэгүүд, их эмчийн салбартай эмнэлэг, худалдаа үйлчилгээний төвүүдтэй Мөн томоохон нүүрс олборлох уурхай, алт олборлох салбар. модны аж ахуй, ХАА, мал аж ахуй, газар тариалангийн бүс нутагт хамрагдана. Улаанбаатар хоттой төмөр зам, автомашины шороон ба цардмал зам, утсан харилцааны ба өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2024 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтож, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

3.5. Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налууугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Уурхайн нөхөн сэргээлт

2024 оны эцсийн байдлаар нийт уурхайн эдэлбэрт нийт 4.2 га талбай өртөж байна. **Техникийн нөхөн сэргээлт.** Ордын хувьд ашиглагдсан орон зай буюу уурхайн ухшийг уурхайн олборлолтын эхэн үеэс хоосон орон зай үүсэх үед дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж уулын ажилтай техникийн нөхөн сэргээлтийн ажлыг давхар явуулснаар тодорхой хэмжээний зардлыг хэмнэж байгаа юм. Техникийн нөхөн сэргээлтийг хийх ихэнх зардал нь ашиглалтын зардалд шингэсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийхийн өмнө ахин хэвгийжүүлэх дагтаршуулах ажил хийгдэнэ. Энэ онд шинээр эвдрэлд орох 3.2 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр байгаа бөгөөд зардал нь ашиглалтын зардалд шингэсэн. Мөн дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил, талбайд тэрбум мод төслийн хүрээнд мод тарихаар тусгав.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “ЭГЭМАЙНИНГ” ХХК-ийн “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Төсөл хэрэгжүүлэгч “ЭГЭМАЙНИНГ” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх ёстой.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	9	
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Уурхайн дотоод замыг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	1000000	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82	
		Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он		
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2024 он		
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он		
	Нийт	1000000						
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008	
		Ажилчдын хотхоны гадна 2 00-ын шинэчлэл, доторлох ажил	Үүний зардал 1000000				2024 он	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон					

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Нийт		1000000					
3	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 он	MNS 5916:2008 MNS 5917:2008
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай,	-	500000	2024 он	MNS 5918:2008
Нийт		500000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Ургамлын зүйлийн бүрдлийн судалгаа	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Орчны хяналт шинжилгээний зардалд	2024 онд 1 удаа	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	500000	2024 он	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
Нийт		500000					
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 3000000						

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 онд уурхайн эдэлбэрт шинээр 4.2 га шинээр талбай өртөж байна. Энэ онд шинээр эвдрэлд орох 3.2 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр байгаа бөгөөд зардал нь ашиглалтын зардалд шингэсэн.

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1	Техникийн нөхөн сэргээлт	га	3.2	-	-	Дотоод овоолго үүсгэх ажлын зардал нь уулын ажлын зардалд орсон	MNS 5914:2008 MNS 5918:2008 MNS5918:2008 MNS 4919:2000 MNS 4920:2000
2	Биологийн нөхөн сэргээлт	М³	-	-	-	2024 онд биологийн нөхөн сэргээлт хийхгүй	
	Нийт					Үйл ажиллагааны зардалд орсон.	

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ТЭРБУМ МОД

“Эгэ майнинг” ХХК нь 2024 онд орон нутгаас заасан чиглэлд дүйцүүлэн хамгаалах ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Сумын нутаг дэвсгэрт орон нутгаас заасан чиглэлийн дагуу	Техникийн нөхөн сэргээлт	Заагдсан талбайд	3 га	-	3000000	2024 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	Зулзаган голын нарсан ойг тэлэх ажилд оролцох	Мод тарих	Заагдсан талбайд			3000000	2024 онд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
	Нийт					6000000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эгэ майнинг” ХХК-ийн “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Хонгор сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол бэртэл, өвчлөлийн жагсаалт гаргаж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн зөвлөмжийг боловсруулж ажилчдын хүртээл болгох	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	100000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
2	Ажилчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллах	Ажлын өдөр эхлэх бүрт зааварчилгаа өгөх	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	-	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
3	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах	Компани	-	-	1000000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
4	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах		Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	1000000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
5	Уурхайн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	200000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
	Нийт					2 300 000		

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Хонгор сумын нэгдсэн хогийн цэгт хогоо ачуулах, тэмдэглэл хөтлөх	кг	-	-	Уурхайн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байрны гадна байршуулах	тоо	100 000	3	300 000	
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах		Га	200 000	0.3	200 000	
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан хаягдал тос, маслог зориулалтын цэгт хуримтлуулах, дугуй ламп гэх мэтийг дахивар авах газарт тушаана.	Уурхайд ашиглагдаж буй машин болон бусад зүйлс	тоо	300 000	-	300 000	
Нийт							800 000	

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Эгэ майнинг” ХХК-ийн “Хуурай чулуут”-ын алтны шороон орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий "Хуурай чулуут"-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1.	Агаар	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, уурхайн зам	8-р сард	4 цэгт 1 удаа	100000	400000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 6768:2019 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2.	Хөрс	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, засварын талбай	8-р сард	4 цэгт 1 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 4 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25000 төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 75.0 мян.төг <i>Инженер геофизи хөрсний төв лаборатори</i>	225000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS 5850 : 2029 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 – 1987 MNS 2305 - 95
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр бохирын нуур	8-р сард	3 цэгт 1 удаа	Бүрэн шинжилгээний үнэ 140000 төг	420000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ ,	MNS /ISO/ 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS 900:2005 Усны тухай хууль

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

							CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар)	
4	Боловсруулах зардал					1000000		
	Нийт					2045000		



Хяналт шинжилгээ хийх байршил



Зураг 3. Мониторингийн байршлын зураг

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 10. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн үйл ажиллагаанаас газрын төлөв байдал, чанар доройтно	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	MV-022145 талбай	-	-	Газрын тухай хуулийн 58.5
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс газрын доорх усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	Гүний худгаас хангана	-	-	Усны тухай хууль
”Байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	-	2024	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны аудит хийх эрх олгох журам
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	Ажилчид	1000000	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Уул уурхайн үйл ажиллагаанаас ажилчдын	Ажлын байрны хэвийн бус нөхцөлд	Бүх ажилчдыг	Үйл ажиллагаан	Өдөр бүр	

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

эрүүл мэндэд сэргээр нөлөөлж болзошгүй	ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах		ы зардалд орсон		
			1000000		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	-
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		11 сарын 1-нд багтаан			-
3		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		10-р сараас 12-р сарын 1-нд багтаан			-
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-022145 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Хуурай чулуут”-ын алтны шороон ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 12. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3000.0
2	Нөхөн сэргээлт	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ болон тэр бум мод ажлын зардал	6000.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2300.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2045.0
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1000.0
10	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	15145.0

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **15.1 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 7.5 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.